# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3 (528)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай*
- *Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2008 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот　2008 оны нэгдүгээр сарын 21　№3 (528)


## Гарчиг


**Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

| | | | |
|---|---|---|---|
| 49. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 49 |
| 50. | Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 50 |
| 51. | Гэрээ соёрхон батлах тухай | | 50 |

**Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

| | | | |
|---|---|---|---|
| 52. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 01 | 50 |

**Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

| | | | |
|---|---|---|---|
| 53. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай | Дугаар 346 | 50 |
| 54. | Ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 348 | 51 |
| 55. | Суудлын авто машины талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 349 | 51 |
| 56. | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 350 | 53 |
| 57. | Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 351 | 53 |
| 58. | Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 352 | 58 |
| 59. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 353 | 58 |
| 60. | Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 354 | 58 |
| 61. | Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн тухай | Дугаар 355 | 68 |
| 62. | Хөрөнгө гаргах тухай | Дугаар 357 | 68 |


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр　　　Улаанбаатар хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.3 дахь заалтын "импортлох" гэсний дараа "экспортлох, хил дамжуулан тээвэрлэх,", "ашиглах" гэсний дараа ", худалдах, устгах" гэж, мөн хуулийн 15.6 дахь хэсэгт "15.6.7.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх." гэсэн заалт тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.4 дэх заалтын "химийн хорт болон аюултай бодис экспортлох, худалдах ," гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.3, 16.2.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА　Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

### ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5.1 дэх заалтын "импортлох" гэсний дараа "хил дамжуулан тээвэрлэх,", "ашиглах" гэсний дараа ",устгах" гэж, мөн хуулийн 6.1 дэх хэсэгт "6.1.13.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах эрх олгох." гэсэн заалт тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйл:**

"**4 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын ангилал**

4.1.Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь:

4.1.1.хортой;

4.1.2. аюултай гэж тус тус ангилна.

4.2. Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар болон Мянганы сорилтын корпорациар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа АНУ-ын Засгийн газар хоорондын "Мянганы сорилтын гэрээ"-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.1-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурал 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28.2-ыг хүчингүй болгосон хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

### Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэд аюулгүй орчинд тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хот дахь цагдаагийн эргүүлийн байршлыг шинэчлэн тогтоож, 24 цагийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, цагдаагийн алба хаагчдыг ажлын байр,

ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээг 2008 оны 1 дүгээр сард багтаан авч дүнг Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, цагдаагийн нэг албан хаагчийн үйлчлэх хүн амын тоог оновчтой болгох саналыг боловсруулж 2008 оны 1 дүгээр сард Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн норматив болон согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортоор оруулах, худалдах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд тавьж байгаа хяналтын тогтолцоог судалж, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай, Зар сурталчилгааны тухай хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг боловсруулж 2008 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ нарт даалгасугай.

4. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын хэрэгжилтийг 2008 оны 1 дүгээр сард багтаан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгаж, иргэдийн ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч дүнг 2008 оны 2 дугаар сард Засгийн газарт танилцуулахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Раш, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Орон сууцны урт хугацааны зээлд үе шаттайгаар хамруулан цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах, "40000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд шинээр барих орон сууцны хороолол, бичил хэсгүүдийн зураг төсөвт цагдаагийн хэлтэс, тасгийн албан байр, ажиллагсдын орон сууцыг тусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 348** **Улаанбаатар хот**

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн албан тушаалтны нэр хүндэд харш ёс зүйн зөрчил гаргасантай нь холбогдуулж Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдаас гаргасан саналыг харгалзан Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтын Бат-Энхийг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 349** **Улаанбаатар хот**

### Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагуудын суудлын автомашиныг зориулалтаар нь албан тушаалын, албан ажлын, дуудлагын гэж ангилан тогтоож "Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ыг хавсралтын ёсоор батлсугай.

2. Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоногт (баярын болон долоо хоног бүрийн амралтын өдрийг оролцуулан)

дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 70 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан суудлын автомашины түйлтийн лимитийн хэмжээг хатуу мөрдөж ажиллахыг ерөнхий менежерүүдэд, лимитийг мөрдөж байгаа байдалд тавих хяналтыг сайжруулж, хэтрүүлсэн шатахууны үнийг хэрэглэгчээр нөхөн төлүүлж байхыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Ж.Бадраад даалгасугай.

4. Хот доторхи ажил, үйлчилгээнд том оврын, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг (100 км-т 16 литрээс их) суудлын автомашин хэрэглэхийг хориглож, энэ талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг болон төрийн өмчит хуулийн этгээдийн дотоод албан хэрэгцээнд хэрэглэх дуудлагын автомашины тоо, төрлийг тогтоож хяналт тавин ажиллахыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

6. Яам, Засгийн газрын агентлаг, тэдгээрийн харьяа байгууллагуудад өндөр үнэтэй, шатахуун их зарцуулдаг, туулах чадвар өндөртэй суудлын автомашин цаашид худалдаж авахгүй байхыг Засгийн газрын гишүүд болон Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд үүрэг болгосугай.

7. Нэг зуун км-т зарцуулах шатахууны хэмжээ 16 литрээс хэтэрч байгаа туулах чадвар өндөртэй суудлын автомашиныг 2008 оны I улиралд багтаан автомашин дутагдаж байгаа зарим байгууллагад хэрэгцээг нь үндэслэн шилжүүлж, үлдсэн автомашиныг төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтран худалдан борлуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

8. Автомашин худалдан авах хэрэгцээ, шаардлагыг тооцож, автомашины бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж байхыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

9. Албан ажлын автомашин хэрэглэдэг албан тушаалтан өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд ажлын хоногт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр 1 км-ийг 200 төгрөгөөр тооцон зардлыг сар тутам түүнд олгож байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт зөвшөөрсугай.

10. Энэхүү тогтоолын хавсралтын "Нэг"-ийн 1-д заасан албан тушаалтан хөдөө ажлын хэрэгцээний автомашинтай байхыг зөвшөөрч, хавсралтад заасан бусад албан тушаалтан болон яам, Засгийн газрын агентлагуудыг хөдөө ажлын автомашинаар хангаж ажиллахыг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Ж.Бадраад даалгасугай.

11. Эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, хэрэглэсэн шатахууны зардлыг төлүүлэх явдлыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн таслан зогсоохыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

12. Энэ тогтоолд заасан нийтлэг жишгийг баримтлан аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудын автомашин ашиглалтын журам, автомашины тоо, төрлийг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

13. Суудлын автомашин хэрэглэхдээ энэ тогтоолд заасан жишгийг баримтлан ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагын удирдлага болон Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Ч.Батдэлгэр, Улсын ерөнхий прокурор М.Алтанхуяг нарт зөвлөсугай.

14. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 266 дугаар тогтоол, "Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай" Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД**

**Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын хавсралт**

## АЛБАН ТУШААЛЫН БОЛОН АЛБАН АЖЛЫН СУУДЛЫН АВТОМАШИН ХЭРЭГЛЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Нэг. Албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан

1. Засгийн газрын гишүүн

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга

Хоёр. Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, дэд дарга болон хэлтсийн дарга

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх

3. Дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга

4. Ерөнхий сайдын зөвлөх
5. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн дарга
6. Аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Улаанбаатар хотын ерөнхий менежер
7. Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга
8. Шадар сайдын ахлах зөвлөх

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 350** **Улаанбаатар хот**

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 642 төгрөг 85 мөнгө буюу сард 108000 (нэг зуун найман мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 240 дүгээр тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 351** **Улаанбаатар хот**

**Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28.4.3, 28.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтын, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралтын, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 5 дугаар хавсралтын, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 6 дугаар хавсралтын, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 7 дугаар хавсралтын, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 8 дугаар хавсралтын, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод жишгийг 9 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Төрийн албан хаагчийн цалин хөлсний асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилгоор төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин хөлсний бүтэц, нийгмийн баталгааны цэгцтэй бодлогыг тодорхойлж Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжийг судалсны үндсэн дээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж 2008 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 237 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТЗ-1 | ТЗ-2 | ТЗ-3 | ТЗ-4 | ТЗ-5 | ТЗ-6 | ТЗ-7 | ТЗ-8 | ТЗ-9 | ТЗ-10 | ТЗ-11 | ТЗ-12 | ТЗ-13 | ТЗ-14 |
| 1 | 161059 | 175050 | 191219 | 203967 | 215781 | 236342 | 259977 | 285974 | 314572 | 346029 | 363330 | 381964 | 401060 | 409082 |
| 2 | 173271 | 188322 | 205718 | 219432 | 232142 | 254262 | 279689 | 307657 | 338423 | 372266 | 390879 | 410611 | 431141 | 439763 |
| 3 | 185485 | 201598 | 220219 | 234901 | 248506 | 272186 | 299405 | 329345 | 362280 | 398507 | 418433 | 439354 | 461321 | 470548 |
| 4 | 197302 | 214441 | 234249 | 249866 | 264338 | 289526 | 318479 | 350327 | 385360 | 412001 | 426914 | | | |
| 5 | 209117 | 227282 | 248276 | 264828 | 280167 | 306864 | 337550 | 371305 | 408436 | 425493 | 435395 | | | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

## УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АА-11 | АА-10 | АА-9 | АА-8 | АА-7 | АА-6 | АА-5 | АА-4 | АА-3 | АА-2 | АА-1 |
| 1 | 203967 | 215781 | 236342 | 259977 | 285974 | 314572 | 346029 | 363330 | 381964 | 401060 | 409082 |
| 2 | 219432 | 232142 | 254262 | 279689 | 307657 | 338423 | 372266 | 390879 | 410611 | 431141 | 439763 |
| 3 | 234901 | 248506 | 272186 | 299405 | 329345 | 362280 | 398507 | 418433 | 439354 | 461321 | 470548 |
| 4 | 249866 | 264338 | 289526 | 318479 | 350327 | 385360 | 412001 | 426914 | | | |
| 5 | 264828 | 280167 | 306864 | 337550 | 371305 | 408436 | 425493 | 435395 | | | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТТ-1 | ТТ-2 | ТТ-3 | ТТ-4 | ТТ-5 | ТТ-6 | ТТ-7 | ТТ-8 | ТТ-9 | ТТ-10 | ТТ-11 | ТТ-12 | ТТ-13 | ТТ-14 | ТТ-15 | ТТ-16 | ТТ-17 | ТТ-18 |
| 1 | 139125 | 153037 | 160507 | 172766 | 177328 | 186017 | 195318 | 205084 | 215338 | 226105 | 237411 | 249281 | 261745 | 274832 | 288573 | 331859 | 348452 | 355420 |
| 2 | 151347 | 166481 | 174608 | 187944 | 192906 | 202359 | 212477 | 223101 | 234256 | 245969 | 258267 | 271181 | 284740 | 298977 | 313925 | 361013 | 379063 | 386644 |
| 3 | 163182 | 179501 | 188262 | 202642 | 207992 | 218184 | 229093 | 240548 | 252575 | 265204 | 278464 | 292388 | 307007 | 322357 | 338474 | 389245 | 408707 | 416880 |
| 4 | 174218 | 191639 | 200994 | 216345 | 222057 | 232939 | 244586 | 256815 | 269656 | 283139 | 297295 | 312160 | 327768 | 344157 | 361364 | | | |
| 5 | 185586 | 204145 | 214110 | 230463 | 236548 | 248139 | 260546 | 273574 | 287252 | 301615 | 316696 | 332531 | 349157 | 366615 | 384945 | | | |

**Засгийн газрын 2007 оны 351 дүгээр**
**тогтоолын 4 дүгээр хавсралт**

## Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишиг

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮШУ-1 | ТҮШУ-2 | ТҮШУ-3 | ТҮШУ-4 | ТҮШУ-5 | ТҮШУ-6 | ТҮШУ-7 |
| 1 | 208691 | 277194 | 304913 | 329459 | 355815 | 384281 | 415023 |
| 2 | 210797 | 279991 | 307990 | 332753 | 359373 | 388123 | 419172 |
| 3 | 216148 | 287098 | 315808 | 341072 | 368358 | 397827 | 429653 |
| 4 | 229722 | 305128 | 326731 | | | | |
| 5 | 244865 | 325242 | 337653 | | | | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 5 дугаар хавсралт

Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний
албан тушаалын цалингийн доод жишиг

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮМБ-1 | ТҮМБ-2 | ТҮМБ-3 | ТҮМБ-4 | ТҮМБ-5 | ТҮМБ-6 | ТҮМБ-7 | ТҮМБ-8 | ТҮМБ-9 |
| 1 | 208691 | 229560 | 241038 | 277194 | 304913 | 329459 | 355815 | 384281 | 415023 |
| 2 | 210797 | 231877 | 243471 | 279991 | 307990 | 332753 | 359373 | 388123 | 419172 |
| 3 | 216148 | 237762 | 249650 | 287098 | 315808 | 341072 | 368358 | 397827 | 429653 |
| 4 | 229722 | 252694 | 265329 | 305128 | 326731 | | | | |
| 5 | 244865 | 269351 | 282819 | 325242 | 337653 | | | | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралт

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудын
төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишиг

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮБД-1 | ТҮБД-2 | ТҮБД-3 | ТҮБД-4 | ТҮБД-5 | ТҮБД-6 | ТҮБД-7 | ТҮБД-8 |
| 1 | 164973 | 181470 | 208691 | 229560 | 241038 | 277194 | 304913 | 329459 |
| 2 | 166638 | 183302 | 210797 | 231877 | 243471 | 279991 | 307990 | 332753 |
| 3 | 170868 | 187954 | 216148 | 237762 | 249650 | 287098 | 315808 | 341072 |
| 4 | 181598 | 199758 | 229722 | 252694 | 265329 | 305128 | 326731 | |
| 5 | 193569 | 212926 | 244865 | 269351 | 282819 | 325242 | 337653 | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮЭМ-1 | ТҮЭМ-2 | ТҮЭМ-3 | ТҮЭМ-4 | ТҮЭМ-5 | ТҮЭМ-6 | ТҮЭМ-7 | ТҮЭМ-8 | ТҮЭМ-9 |
| 1 | 164973 | 181470 | 208691 | 229560 | 241038 | 277194 | 304913 | 329459 | 355815 |
| 2 | 166638 | 183302 | 210797 | 231877 | 243471 | 279991 | 307990 | 332753 | 359373 |
| 3 | 170868 | 187954 | 216148 | 237762 | 249650 | 287098 | 315808 | 341072 | 368358 |
| 4 | 181598 | 199758 | 229722 | 252694 | 265329 | 305128 | 326731 | | |
| 5 | 193569 | 212926 | 244865 | 269351 | 282819 | 325242 | 337653 | | |

тогтоолын 8 дугаар хавсралт

### СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮСҮ-1 | ТҮСҮ-2 | ТҮСҮ-3 | ТҮСҮ-4 | ТҮСҮ-5 | ТҮСҮ-6 | ТҮСҮ-7 | ТҮСҮ-8 | ТҮСҮ-9 | ТҮСҮ-10 | ТҮСҮ-11 |
| 1 | 149635 | 157117 | 164973 | 181470 | 208691 | 229560 | 241038 | 277194 | 304913 | 329459 | 355815 |
| 2 | 151146 | 158703 | 166638 | 183302 | 210797 | 231877 | 243471 | 279991 | 307990 | 332753 | 359373 |
| 3 | 154982 | 162731 | 170868 | 187954 | 216148 | 237762 | 249650 | 287098 | 315808 | 341072 | 368358 |
| 4 | 164715 | 172951 | 181598 | 199758 | 229722 | 252694 | 265329 | 305128 | 326731 | | |
| 5 | 175573 | 184351 | 193569 | 212926 | 244865 | 269351 | 282819 | 325242 | 337653 | | |

Засгийн газрын 2007 оны 351 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралт

### ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮ-1 | ТҮ-2 | ТҮ-3 | ТҮ-4 | ТҮ-5 | ТҮ-6 | ТҮ-7 | ТҮ-8 | ТҮ-9 | ТҮ-10 | ТҮ-11 | ТҮ-12 |
| 1 | 140227 | 149635 | 157117 | 164973 | 181470 | 208691 | 229560 | 241038 | 277194 | 304913 | 329459 | 355815 |
| 2 | 141628 | 151146 | 158703 | 166638 | 183302 | 210797 | 231877 | 243471 | 279991 | 307990 | 332753 | 359373 |
| 3 | 145134 | 154982 | 162731 | 170868 | 187954 | 216148 | 237762 | 249650 | 287098 | 315808 | 341072 | 368358 |
| 4 | 154248 | 164715 | 172951 | 181598 | 199758 | 229722 | 252694 | 265329 | 305128 | 326731 | | |
| 5 | 164416 | 175573 | 184351 | 193569 | 212926 | 244865 | 269351 | 282819 | 325242 | 337653 | | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 352** **Улаанбаатар хот**

**Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг доор дурдсанаар шинэчлэн тогтоож 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай:

| | |
|---|---|
| Дүүргийн Засаг дарга | 354900-418500 |
| Сумын Засаг дарга | 330150-392700 |
| Хорооны Засаг дарга | 228987-271906 |
| Багийн Засаг дарга | 198790-239524 |

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 353** **Улаанбаатар хот**

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 96 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Төрийн захиргааны албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтын" гэсэн хэсэг, "Журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 239 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 354** **Улаанбаатар хот**

**Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 7.10, 9.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтын, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 2 дугаар хавсралтын, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 3 дугаар хавсралтын, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 4 дүгээр хавсралтын, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 5 дугаар хавсралтын, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 6 дугаар хавсралтын, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг 7 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 236 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

| Төрийн захиргааны албан тушаалын ангилал | Тухайн ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаал, тэдгээртэй адилтгах албан тушаал | Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт | Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл | Төрийн захиргааны албан тушаалын бүлэг, нэр: Төрийн захиргааны байгууллагын | Төрийн захиргааны албан тушаалын бүлэг, нэр: Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал |
|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| ТЭРГҮҮН ТҮШМЭЛ | Яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах албан тушаал | Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг боловсруулах хэрэгжүүлах үүрэг бүхий байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг тосгийн Ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна. Байгууллагын төсөв болон төрийн тусгай сангийн ашиглалтын талаар хариуцлага хүлээнэ. | ТЗ-14 | 1. Яамны Төрийн нарийн бичгийн дарга | |
| | | | ТЗ-13 | 1. Засгийн газрын агентлагийн дарга | 1. Нийслэлийн Засаг даргын орлогч<br>2. Улаанбаатар хотын ерөнхий менежер<br>3. Чөлөөт бүсийн захирагч |
| ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛ | Яамны газрын дарга, түүний орлогч, тэдгээртэй адилтгах албан тушаал | Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлого боловсруулах хэрэгжүүлах үүрэг бүхий байгууллагын бүтцийн нэгжийг удирдах, бодлогын тодорхой чиглэлийг хэрэгжүүлах үүрэг хүлээж ажлын гүйцэтгэл, үр дүнг тэргүүн түшмэлийн өмнө хариуцна | ТЗ-12 | 1. Яамны газрын дарга<br>2. Засгийн газрын агентлагийн дэд дарга<br>3. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дарга | 1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга<br>2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга<br>3. Аймгийн Засаг даргын орлогч<br>4. Чөлөөт бүсийн ерөнхий менежер |
| | | | ТЗ-11 | 1. Яамны газрын орлогч дарга | 1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга<br>2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга |
